

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/03

Арвайхээр сум

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинаар
дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай” А/25 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Пфайзер-БиоНТех үйлдвэрлэгчийн “Комирнэти” Хоёр цэнт (SARS-CoV-2 эх хувилбарын болон Омикроны BA.4/BA.5) вакцинаар батлагдсан зааврын дагуу 12-оос дээш насны иргэдийг сайн дурын үндсэн дээр нэмэлт тунгаар вакцинжуулах ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
2. Пфайзер-БиоНТех үйлдвэрлэгчийн “Комирнэти” Хоёр цэнт (SARS-CoV-2 эх хувилбарын болон Омикроны BA.4/BA.5) вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.
3. Пфайзер-БиоНТех үйлдвэрлэгчийн “Комирнэти” вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах арга хэмжээг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөн ажиллахыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАНҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНБАЯР

622301010

Эрүүл мэндийн газрын 2025 оны 01 дүгээр
сарын 23 ны өдрийн 103 дугаар
тушаалын хавсралт

Пфайзер-БиоНТех үйлдвэрлэгчийн "Комирнэти" Хоёр цэнт (SARS-CoV-2 эх
хувилбарын болон Омикроны BA.4/BA.5) вакцины хуваарь

Д.д	Дархлаажуулалтын нэгж	Комирнэти 2 цэнт вакцин
1	Баруунбаян-Улаан	10
2	Бат-Өлзий	25
3	Баянгол	10
4	Баян-Өндөр	10
5	Богд	25
6	Бүрд	10
7	Гучин-Ус	10
8	Есөн зүйл	10
9	Зүүнбаян-Улаан	10
10	Нарийнтээл	10
11	Өлзийт	10
12	Сант	10
13	Тарагт	10
14	Төгрөг	10
15	Уянга	25
16	Хайрхандулаан	10
17	Хужирт	25
18	Энэрэл Хархорин	35
19	Нарны дөш	35
20	Уянсэтгэл	30
21	Түшигдөлгөөн	30
	Нийт	360